



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 19

Хажуу шинэ ус

Сумын баяр наадмын төсөв
батлах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сум үүсэн байгуулагдсаны 95 жилийн ой, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийг 12.020.000 төгрөгөөр баталж төсвийн задаргааг хавсралтаар баталсугай.

2. Сумын баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд шаардагдах төсвийн бүрдүүлэлтэнд анхаарах, баяр наадмыг зохион байгуулах комиссыг үүрэгжүүлж, бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН



480219043

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны...⁰⁷
сарын 03-ны өдрийн 19-дүгээр тогтоолын хавсралт

Говь-Угтаал сумын түүхт 95 жилийн ойн баяр наадмын
зардлын төсвийн задаргаа

№	Зардлын гүйлгээ	тоо /ш/	Нэг бүрийн үнэ	Бүгд
Морины бай				
1	Түрүү морь	6	250000	1500000
2	Аман хүзүү	6	200000	1200000
3	Айргийн 3-т хурдалсан	6	150000	900000
4	Айргийн 4-т хурдалсан	6	100000	600000
5	Айргийн 5-т хурдалсан	6	100000	600000
6	Даянгийн даага	1	100000	100000
7	6-д хурдалсан	6	30000	180000
8	7-д хурдалсан	6	20000	120000
9	8.9.10 -т хурдалсан	18	10000	180000
10	Унаач хүүхдийн гарын бэлэг	31	20000	620000
11	Морь цоллооч	6	10000	60000
12	Өргөмжлөл	30	10000	300000
13	Медаль	30	5000	150000
14	Бариад орсон морь тус бүр	150	2000	300000
Бүгд				6810000
Бөхийн бай шагнал				
1	Түрүүлсэн	1	200000	200000
2	Үзүүрлэсэн	1	150000	150000
3	Шөвгөрсөн	2	100000	200000
4	Шөвгийн 4-т	4	10000	40000
5	2 давсан бөх	8	5000	40000
6	1 давсан бөх	16	3000	48000
7	өргөмжлөл	4	10000	40000
8	Медаль	4	5000	20000
Бүгд				738000
Хүүхдийн барилдаан				
1	Түрүүлсэн	2	20000	40000
2	Үзүүрлэсэн	2	15000	30000
3	Шөвгөрсөн	4	10000	40000
4	Хүүхдийн өргөмжлөл	8	8000	64000
5	Медаль	8	5000	40000
Бүгд				214000
бөхийн нийт шагнал				952000

Шагайн харвааны бай шагнал					
1	Хувийн цуваа	1-р байр	1	80000	80000
2		2-р байр	1	60000	60000
3		3-р байр	1	40000	40000
4	Багийн цуваа	1-р байр	7	10000	70000
5		2-р байр	7	8000	56000
6		3-р байр	7	5000	35000
7	Өргөмжлөл		6	10000	60000
8	Медаль		24	5000	120000
Бүгд					521000
Сур харвааны бай шагнал					
1	Түрүүлсэн		2	80000	160000
2	дэд байр		2	60000	120000
3	3-р байр		2	40000	80000
4	Өргөмжлөл		6	10000	60000
5	Медаль		6	5000	30000
Бүгд					450000

Шатахууны зардал							
№	Зардлын төрөл	хэдэн нас	хэд эн км	шатахууны төрөл	нэг бүрийн үнэ	хэмжээ	бүгд үнэ
1	ЗДТГ -ын машин	6	260	АИ-92	1960	70	137200
2	Эмнэлэгийн машин	6	260	АИ-92	1960	50	98000
3	Тойрог дээр мотоцикль	6	210	А-80	1880	10	18800
4	Төхөөрөмж ачих машин		50	ДТ	2430	20	48600
5	Аж ахуйн комисс		30	АИ-92	2430	30	72900
6	УБ хот айраг идээ авчрах		500	АИ-92	1960	100	196000
7	Хэв журам эргүүл		210	АИ-92	1960	50	98000
Бүгд							669500

Хүлээн авалтын зардал				
№	Зардлын төрөл	тоо хэмжээ	нэг бүрийн үнэ	нийт үнэ
1	Ундаа	50	1100	55000
2	Зууш	50	2000	100000
3	Хоол	40	6500	260000
4	Тавгийн чихэр	3	10000	30000
5	Айраг	38	2500	95000
6	Жимс	10	10000	100000

7	огурцы	2	7500	15000
8	Сонгино	2	1500	3000
9	төмс	10	1200	12000
Бүгд				670000

Аж ахуйн зардал

1	Айраг	300	2500	750000
2	Идээний боов	65	2000	130000
3	Идээний өнгө /ааруул/	5	20000	100000
4	Тагш	5	5000	25000
5	Айрагны аяга	10	5000	50000
6	Морь мялаах айраг	45	2500	112500
7	Наадмын талбайн засвар	1	120000	120000
8	Хулдаасан хэвлэл	1	120000	120000
Бүгд				1407500

Комиссын хоолны зардал

1	Морины комисс	17	10000	170000
2	Бөхийн комисс	9	10000	90000
3	Шагайн комисс	3	10000	30000
4	Сурын комисс	3	10000	30000
5	Соёлын комисс	5	10000	50000
6	хэв журмын комисс	5	10000	50000
7	Аж ахуйн комисс	12	10000	120000
БҮГД				540000
Наадмын нийт зардал				12020000



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 03 өдөр

Дугаар 20

Хажуу шинэ ус

Төрийн дээд шагналаар
шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ :

1. Говь-Угтаал сумын төр, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээл, идэвхи зүтгэл гарган ажилласан 2 дугаар багийн малчин Амаасэрээтэрийн Шатарбазар, Засаг даргын тамгын газрын дарга Гэлэгдаржаагийн.Эрдэнэцэцэг нарыг "Алтан гадас" одонгоор, Засаг даргын тамгын газрын санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч Эрдэнэбилэгийн Уранбилэгийг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Шагналын материалыг холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлж, аймгийн холбогдох хэлтэст хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.



ДАРГА *В.Нямсүрэн* В.НЯМСҮРЭН

480219046



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 21

Хажуу шинэ ус

Цалинг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга В.Нямсүрэнгийн албан тушаалын сарын үндсэн цалинг 974266 (Есөн зуун далан дөрвөн мянга хоёр зуун жаран зургаан) төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2. Үндсэн цалин, цалингийн нэмэгдлийг холбогдох заавар журмын дагуу тооцож 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч П.Алтансарнайд зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 05 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН



480219049



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 22

Хажуу шинэ ус

Амьжиргааг дэмжих зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.5 дах заалт, Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүнийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай.

Зөвлөлийн дарга: Г.Эрдэнэцэцэг /ЗДТГ-ын дарга/

Гишүүд:

Г.Угтахбаяр /2-р багийн эмч/

Б.Гүнсмаа /Ахмадын хорооны дарга/

Ж.Мөнхдэлгэр /Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгч/

Д.Баасансүрэн /Иргэдийн төлөөлөл/

Б.Воля /Иргэдийн төлөөлөл/

Нарийн бичгийн дарга Н.Өлзийтогтох /хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

2. Хууль, дүрмийн дагуу ажиллаж, тайлангаа хагас, бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг зөвлөлийн дарга (Г.Эрдэнэцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



В.НЯМСҮРЭН

480219050



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 23

Хажуу шинэ ус

Төрийн дээд шагналаар
шагнуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дах заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар баталсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журмыг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Говь-Угтаал сумын хөдөө аж ахуйн салбарт олон жил үр бүтээл, идэвхи зүтгэл гарган ажилласан тус сумын уугуул иргэн Падтогтохын Юндэн, 1 дүгээр багийн малчин Вандангийн Нямдорж нарыг "Алтан гадас" одонгоор, 3 дугаар багийн малчин Довдонбалбарын Сэдэдийг "Хөдөлмөрийн хүндэт медаль"-иар шагнуулахаар аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай.

2. Шагналын материалыг холбогдох хууль журмын дагуу бүрдүүлж, аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэхийг сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА  В.НЯМСҮРЭН



480219052



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 24

Хажуу шинэ ус

Цалинг шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ний өдрийн 275, 277 дугаар тогтоолыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан тушаалын ангилал, зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан Д.Жаргалмаагийн албан тушаалын зэрэглэл, цалингийн хэмжээ, шатлалыг ТЗ-ийн 9-5 болгож сарын үндсэн цалинг 968197 төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2. Үндсэн цалин, төрийн захиргааны албан хаагчдад олгодог нэмэгдлүүдийг холбогдох заавар журмын дагуу тооцож 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг нягтлан бодогч (П.Алтансарнай)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  В.НЯМСҮРЭН



480219053



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 25

Хажуу шинэ ус

"Тогтвортой хөгжил-түншлэл" хамтын ажиллагааны
салбар зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.7, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 69 дүгээр тогтоолын 4 дүгээр заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. "Тогтвортой хөгжил-түншлэл" хамтын ажиллагааны салбар зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд байгуулж ажиллуулсугай.

Зөвлөлийн дарга: Ө.Мөнх-Амгалан /засаг дарга/

Гишүүд: Д.Жаргалмаа /ИТХын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/
Д.Амгалан / ААН-ийн төлөөлөл/
Ж.Мөнхдэлгэр /ТББ-ын төлөөлөл /
Д.Дагмидмаа /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч/
Т.Цэрэнчунт /ХАА тасгийн дарга/
Б.Номин-Эрдэнэ /Сургуулийн захирал/
Г.Энхдэлгэр /Эрүүл мэндийн төвийн эрхлэгч/
Э.Уранбилэг /Ерөнхий нягтлан бодогч/
Н.Өлзийтогтох /Хөдөлмөр, халамж хариуцсан мэргэжилтэн/

Нарийн бичгийн дарга: Г.Эрдэнэцэцэг /ЗДТГ-ын дарга/

2.Зөвлөлийн ажиллах журмыг мөрдөн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг зөвлөлийн дарга (Ө.Мөнх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ДАРГА



В.НЯМСҮРЭН

480219055